

“МОНГОЛ-ХЯТАДЫН МӨНГӨ САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА” СЭДЭВТ АНХДУГААР ФОРУМ

Монгол Улсын Шнжлэх Ухааны Академи, Олон Улс Судлалын Хүрээлэн, БНХАУ-ын Санхүү Эдийн Засгийн Төв Их сургууль хамтран 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Гадаад Харилцааны Яамны “Зөвшилцөл” хурлын танхимд “Монгол-Хятадын мөнгө санхүүгийн хамтын ажиллагаа” сэдэвт анхдугаар форумыг зохион байгууллаа. Энэхүү форумын дэмжигч байгууллагаар Монгол Улсын Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Монголын Хөрөнгийн бирж, Худалдаа хөгжлийн банк оролцож, хоёр орны эрдэмтэн судлаачдаас гадна холбогдох яам агентлаг, судалгаа, сургалт, банк санхүү, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төлөөлсөн 100 гаруй зочид төлөөлөгчид уригдан оролцов.

Форумын нээлтэд Эдийн засгийн хөгжлийн дэд сайд О.Чулуунбат, ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны худалдааны зөвлөх Сунь Вэйрэн нар баяр хүргэж үг хэллээ.

Сүүлийн жилүүдэд БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш, хамгийн том хөрөнгө оруулагч болоод байгаа учир хоёр орны мөнгө санхүүгийн харилцаа, хамтын ажиллагаатай холбогдох олон чухал асуудлаар хоёр орны эрдэмтэд судлаачид, мэргэжилтнүүд санал солилцон, хамтын ажиллагааны цаашдын боломжийн талаар өргөн хүрээнд хэлэлцүүлсэн бөгөөд хурлын бүх илтгэлийг сэтгүүлийн энэ дугаарт бүрэн эхээр нь хэвлүүлж байна.

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦ